



Хураангуй

- Герман улсад ХАА-н техникийн дундын үйлчилгээг ХАА-н туслан гүйцэтгэгчид болон Техник зуучлалын дундын төвүүд олон жилийн турш эрхэлж байна.
- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтрал мал аж ахуйн салбарт нилээд тархсан, харин газар тариалангийн техникийн дундын үйлчилгээнд гүйцэтгэх үүрэг бага.
- ТЗДТ-үүд болон туслан гүйцэтгэгчдийн тариаланчдад үзүүлдэг үйлчилгээ тухайн орон нутгийн механикжуулалтын хээргцээг бүрэн хангадаг.
- ТЗДТ-үүд механикжуулалтын үйлчилгээг тариаланч нэг бүрийн хэрэгцээнд нийцүүлэхийн тулд зохион байгуулалтын хувьд уян хатан байдаг.
- Дундын үйлчилгээнд ашиглаж буй ХАА-н техникийн ашиглалтын хуваарийг зөв төлөвлөхгүй бол тариаланчдын ажлыг хоцроох, үүнээс шалтгаалж нэмэлт зардал гарах эрсдэлтэй.
- Монгол орны хувьд эн тэргүүнд 100 га хүртэлх талбайтай төмс, хүнсний ногооны тариаланчдад техникийн дундын үйлчилгээ нэвтрүүлэх нь зүйтэй.

ХАА-н техникийн дундын үйлчилгээ – Давуу тал, эрсдэлүүд

Удиртгал

ХАА-н техникийн дундын үйлчилгээ Герман улсад өнгөрсөн зууны 50-иад оны үед нэвтэрчээ. Анх уг үйлчилгээ нь дэлхийн 2-р дайны дараа үүссэн ажиллах хүчний хомсдол, түүнээс шалтгаалж ХАА-н механикжуулалт эрчимжсэнтэй холбоотойгоор бий болсон бол яваандаа ХАА-н техникийг тариаланчид тус бүртээ худалдан авахад бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах боломжгүй тул хөрөнгө оруулалтын зардлаа нөхөж чадахгүй болсноос шалтгаалан дэлгэрсэн байна.

Тариаланчид дундын техник ашиглахын тулд зохион байгуулалтын төрөл бүрийн хувилбаруудыг бий болгосны дотор хувийн хэвшлийн ХАА-н туслан гүйцэтгэгчид, тариаланчдын албан ба албан бус хамтралууд ба техник зуучлалын дундын төв (ТЗДТ) гэсэн хувилбарууд голлож байна. Ялангуяа туслан гүйцэтгэгчид болон ТЗДТ-үүд Герман улсын өнцөг булан бүрт ажиллаж байна. Харин ХАА-н механикжуулалтын хамтрал харьцангуй ховор.

1. ХАА-н туслан гүйцэтгэгчид

Иргэд, ААН-үүдийн ажилд туслахад чиглэсэн төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг ААН-үүдийг туслан гүйцэтгэгчид гэдэг. ХАА-н салбарын туслан гүйцэтгэгчдийг “ХАА-н үйлчилгээ эрхлэгчид”, “ХАА, ландшафтын үйлчилгээний нэгжүүд”, “Орон нутгийн үйлчилгээний байгууллагууд” гэх мэтээр нэрлэсэн тохиолдлууд бий.

ХАА-н салбарын туслан гүйцэтгэгчид анх зөвхөн үрлэгээ, ургац хураалт, бордоо, ургамал хамгааллын бодис цацах зэрэг зөвхөн тариалангийн технологийн үйлдлүүдийг тариаланчдын захиалгаар төлбөртэй гүйцэтгэдэг байсан бол орчин үед илүү өргөн цар хүрээг хамрах болжээ. Тухайлбал ногооны аж ахуй, ландшафтын арчилгаа, барилга байгууламж барих, хувийн хэвшил, орон нутгийн захиргааны захиалгаар тохижилт, засварын ажил гүйцэтгэх зэрэг төрөл бүрийн чиглэлүүдээр туслан гүйцэтгэх үйлчилгээ эрхэлж байна.

ХАА-н туслан гүйцэтгэгчдийг төрөл бүрийн шалтгаанаар ажиллуулж болно. Гэхдээ голчлон тариаланчдад ХАА-н техник, эсвэл ажиллах хүч дутагдалтайн улмаас зарим ажлаа туслан гүйцэтгэгчдээр хийлгэх шаардлага үүсдэг.



Жишээлбэл тариалангийн зарим аж ахуйнуудад үр тарианы комбайн, бүдүүн тэжээл хураагч зэрэг ургац хураалтын техник байхгүй байж болно. Энэ тохиолдолд ургац хураалтыг туслан гүйцэтгэгчдээр гүйцэтгүүлэх шаардлага үүснэ. Түүнчлэн хураасан будаа, тэжээлийг цэвэрлэх, ачих, тээвэрлэх зэрэг ажлуудад ч мөн туслан гүйцэтгэгчдийг захиалж ажиллуулах нь цөөнгүй.

ХАА-н туслан гүйцэтгэгчдэд түүнчлэн орон нутгийн захиргаанаас төрөл бүрийн ажил, үүргүүдийг хүлээлгэдэг. Хот суурингийн ногоон байгууламж, байгалийн тусгай хамгаалалттай бүс, гадаргын ба гүний ус, далай, тэнгисийн эргийн хамгаалалт, арчилгааны ажлуудыг Герман улс даяар хот суурингууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийн захиалгаар ХАА-н туслан гүйцэтгэгчид хариуцан гүйцэтгэж байна.

ХАА-н туслан гүйцэтгэгчид чөлөөт өрсөлдөөний зарчмаар ажиллана. Хоорондоо өрсөлдөх боловч заримдаа хамтран ажиллах тохиолдол ч бий. Үйлчилгээний үнэ хөлсийг өөрсдөө тогтоодог. Үйлчилгээний төрөл, хэлбэрүүдийг тухайн орон нутгийнхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тогтоох бөгөөд зарим туслан гүйцэтгэгчид тодорхой цөөн ажил үүргээр төрөлжсөн байхад зарим нь “Full-Liner” (орч. “Иж бүрэн үйлчилгээ эрхлэгчид”) буюу газар тариалангийн технологийн бүх үйлдлүүдийг цогцоор нь гүйцэтгэх хэмжээнд ажилладаг. Ийм туслан гүйцэтгэгчид аж ахуйн эзэдтэй гэрээ байгуулж, тухайн аж ахуйн газар тариалангийн үйлдвэрлэлийг бүхэлд нь хариуцан эрхлэх тохиолдлууд ч бий.

ХАА-н туслан гүйцэтгэгчид өндөр үнээр худалдан авсан техник, тоног төхөөрөмжөө бүрэн хүчин чадлаар нь ашиглах, үүний тулд ажлын захиалгуудаа аль болох урьдчилан авч, гэрээ байгуулж баталгаажуулахыг эрмэлздэг. Гэвч практикт ихэнх ажлын захиалгыг тухайн ажил гүйцэтгэхийн өмнө л хүлээн авдаг.

Туслан гүйцэтгэгчид хөрөнгө оруулалтаа өөрийн ба зээлийн эх үүсвэрээс бүрдүүлдэг. Зээл гэдэгт мөн ХАА-н техник үйлдвэрлэгчдийн санал болгодог лизингийн гэрээ багтана. Үйлчилгээ үзүүлэхдээ өөрсдийн мэргэжилтнүүд, мэргэжлийн ажилчдаа, оргил ачааллын үеэр туслах ажилчид нэмж авч ажиллуулдаг. ХАА-н туслан гүйцэтгэгчид орон нутгийн Техник зуучлалын дундын төвүүдтэй хамтран ажиллах жишиг нилээд тархсан.

2. ХАА- үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтрал

Герман улсад ХАА-н эрхлэгчдийн хамтрал харьцангуй ховор. Ихэвчлэн ажлын ачааллаа хуваалцах, ажлын цаг хэмнэх, ХАА-н барилга байгууламжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж, хөрөнгө оруулалтын зардлаа нөхөхийн тулд хамтран ажиллах зорилгоор хоёр аж ахуй хамтран ажиллагааны зохион байгуулалтад ордог.

Хамтын ажиллагааны энэхүү загвар мал аж ахуйн салбарт, тэр дундаа саалийн фермерийн аж ахуйд голчлон тархсан. Учир нь саалийн фермүүдэд ажлын ачаалал өндөр, ажлаа хуваалцаж хийх хэрэгцээ нилээд гардаг. Газар тариалангийн ажлаа хамтарч гүйцэтгэх зорилгоор ямар нэг хэлбэрээр хамтрал байгуулсан тохиолдол ховор боловч бий. Энэ тохиолдолд трактор, тракторт угсардаг багажууд, ургац хураалтын ба тээвэрлэлтийн техникийг хамтран худалдан авна.

Хамтран ажиллах гэрээний заалтуудаа зөв томъёолох, хамтрал татан буугдсан тохиолдолд хохирол учрахаас сэргийлэхийн тулд ХАА-н хамтралыг анх байгуулахдаа эдийн засагч, татварын мэргэжилтэн, хуульч, санхүүч зэрэг мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авч, сайтар бэлтгэх шаардлагатай. Түүнчлэн жилийн эцсийн тайлан баланс гарсны дараа ашиг хуваарилах, дундын ашгийг захиран зарцуулахад мэргэжлийн тусламж авах шаардлага гардаг.

Хамтын ажиллагаанд үүсэж болзошгүй сэтгэл зүйн асуудлуудыг дутуу үнэлж болохгүй. Гишүүдийн хувийн зан араншин, олон жилийн турш хэвшсэн сэтгэлгээ, ажлын арга барилууд хоорондоо зөрчилдөх тохиолдол гарч болно. Ер нь хүмүүсийн хоорондын асуудлууд л ХАА-н хамтрал татан буугдах, эсвэл огт байгуулагдахгүй байх гол шалтгаан болдог.

Герман улсын зарим ТЗДТ-үүд орон нутгийн түвшинд ХАА-н механикжуулалтын хамтрал байгуулж, удирдан ажилладаг туршлага бий. Ийм хамтрал хэрхэн ажилладаг талаар ТЗДТ-үүдийн талаарх хэсгээс үзнэ үү.

3. Техник зуучлалын дундын төв

Техник зуучлалын дундын төвүүдийг (ТЗДТ) тариаланчид өөрсдөө байгуулдаг. ТЗДТ нь ТББ-ын статустай бөгөөд ХАА-н техникийн дундын үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, тариаланч бүр орчин үеийн ХАА-н техникийг бага зардлаар ашиглах боломжийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Нэмэлт чиг үүргүүдэд нь гишүүддээ механикжуулалт, хөдөлмөр зохион байгуулалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гишүүдийн ар гэрт осол, өвчин, үхэл хагацал тохиолдсон үед түр хугацаагаар туслах ажилчид ажиллуулах, гишүүддээ нэмэлт орлого олох боломж бүрдүүлэх зэрэг үүргүүд багтана. ТЗДТ өөрөө ХАА-н техник эзэмшдэггүй.

3.1. Техникийн дундын үйлчилгээний байгууллагын үндсэн зарчмууд

а. Хувийн эзэмшлийн техникийг зуучлан түрээслүүлэх хувилбар

Ихэнх тохиолдолд ТЗДТ-ийн зуучилдаг ХАА-н техникийг гишүүн тариаланчид хувьдаа эзэмшдэг. Өөрөөр хэлбэл техник худалдан авах зардал, арчилгаа, үйлчилгээг эзэд нь өөрсдөө хариуцна. Бусдад түрээсээр ашиглуулахдаа ихэвчлэн тухайн техникийг эзэн нь өөрөө ажиллуулна. Энгийн хийцтэй зарим багажуудыг л дагалдах хүнгүйгээр түрээслүүлдэг. ТЗДТ-ийн зүгээс тариаланчдад шинэ техник худалдан авах, техникээ түрээслүүлэх үнэ хөлсийг тогтоох, түрээсээс олох ашгаа төлөвлөх зэрэгт зөвлөгөө өгч, түрээсийн үйлчилгээний зохион байгуулалт, төлбөр тооцоог хариуцдаг. Зарим тариаланчид томоохон техник худалдан авч, ТЗДТ-өөр зуучлуулан түрээслүүлэх сонирхолтой байхад зарим тариаланчид өөрсдөө техник худалдан авахын оронд ТЗДТ-өөс санал болгосон түрээсийн техник ашиглах сонирхолтой. ТЗДТ орон нутгийнхаа тариаланчдын механикжуулалтын бодит хэрэгцээг сайтар судалж, тариаланчдын гар дээр байгаа техникийн нийт хүчин чадлыг аль болох тухайн орон нутгийн нийт хэрэгцээнд дүйцүүлэх бодлогыг баримталж ажиллана. Энэ хувилбараар ажилладаг ТЗДТ-ийн зарим гишүүд яваандаа ХАА-н туслан гүйцэтгэгчид болох тохиолдол ч гардаг.

ХУВИЙН ТЕХНИКИЙГ ЗУУЧЛАН ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЗАГВАР



б. Хамтын эзэмшлийн техник ашиглах хувилбар

Комбайн болон бусад харьцангуй өндөр үнэтэй ХАА-н техникийг тариаланчид хамтран худалдан авах өөр нэг хувилбар байдаг. Ингэснээр тариаланчид тухайн техникийнхээ хамтын эзэмшигчид бөгөөд хэрэглэгчид болно. Энэ тохиолдолд ТЗДТ хамтралын үүрэг гүйцэтгэнэ. Хамтын эзэмшлийн техникийг худалдан авах ажлыг зохион байгуулж, санхүүжилтийг босгож,

худалдан авсны дараа техникийн арчилгаа, үйлчилгээг хариуцаж, жолоодох хүмүүсийг тариаланчид дундаас томилно. Мөн тухайн техникийг ээлжлэн ашиглах хуваарь гаргаж, төлбөр тооцоог хариуцна. Техник ашиглах төлбөрийг ашиг олох бус, зөвхөн хөрөнгө оруулалтын зардлыг нөхөх түвшинд тогтооно. ХАА-н техникийг хэд хэдэн тариаланчид хамтран эзэмшсэнээр бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломж сайтай тул хамтын эзэмшлийн техник худалдан авахад банкны зүгээс санхүүжилт олгох сонирхол нь илүү өндөр байдаг. Иймд тариаланчид өөрсдөөсөө мөнгө гаргалгүйгээр худалдан авах ч боломжтой.

ХАМТЫН ЭЗЭМШЛИЙН ТЕХНИК АШИГЛАХ ЗАГВАР

ХАА-н техник хамтран эзэмшигч тариаланчид



в. Тариаланчдаас бүтээгдэхүүн худалдан авдаг ААН-ийн оролцоотой хувилбар

Механикжуулалтын өндөр түвшин, өөрөөр хэлбэл ХАА-н техникийн хөрөнгө оруулалт их хэмжээгээр шаарддаг зарим таримлын хувьд механикжуулалтын зардлын тодорхой хэсгийг тухайн таримлыг худалдан авдаг ААН-үүдээс гаргуулах хувилбар байдаг. Түншлэлийн энэ загвар жишээлбэл чихрийн манжингийн тариаланд өргөн тархсан. Чихрийн томоохон үйлдвэрүүд үндсэн түүхий эд болох чихрийн манжинг тариаланчдаас авахдаа бүс нутаг бүрт тодорхой нэг цэгээс төвлөрсөн байдлаар татан авах сонирхолтой байдаг. Уг хэрэгцээ шаардлагын дагуу тариаланчдын талбайгаас чихрийн манжин хураах, цэвэрлэх, ачих, тээвэрлэх, үйлдвэрийн заасан хэмжээ, бусад шаардлагад нийцсэн байдлаар өдөр бүр тогтмол нийлүүлэх ажлыг тухайн орон нутгийн ТЗДТ хариуцна. Ургац хураалтыг тариаланчид өөрсдөө, эсвэл гэрээт туслан гүйцэтгэгчид гүйцэтгэнэ. Талбайд хурааж хадгалах ажлыг тариаланчид, өвөл хучих ажлыг туслан гүйцэтгэгч, цэвэрлэх, зориулалтын техникээр ачих, тээвэрлэх ажлыг туслан гүйцэтгэгчид, эсвэл тариаланчдын бүлгүүд хариуцна. Зөвхөн ургац хураалтын хөлсийг тариаланчид төлж, бусад бүх ажлын зардлыг чихрийн үйлдвэр ТЗДТ-д төлнө.

Биохий үйлдвэрлэгч томоохон цехүүд тариаланчдаас түүхий эдээ татах тохиолдолд ургац хураалтын нийт зардлыг худалдан авагч хариуцдаг жишиг бий. Ургац хураалт ер нь зардал харьцангуй ихтэй, ялангуяа тухайн түүхий эдийг харьцангуй орой хураадаг, үүнээс шалтгаалж тариаланчдад орох орлого удаан хүлээгдэхээр бол наана нь ургац хураалтын зардлыг тариаланчид өөрсдөө төлөх нь хэцүү учраас түншлэлийн энэхүү загвар тариаланчдад маш тустай. Үүний зэрэгцээ худалдан авагчид өөрсдөө түүхий эдээ тариалах, эсвэл тариаланчдад захиалж тариалуулахдаа шаардагдах ХАА-н техникийг худалдан авахад хөрөнгө оруулах тохиолдол ч бий. Аль ч тохиолдолд эдгээр ажлуудыг зохион байгуулахад ТЗДТ гол үүрэг гүйцэтгэнэ.

ТАРИАЛАНЧ – БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТҮНШЛЭЛИЙН ЗАГВАР

ХАА-н техник хамтран эзэмшигч тариаланчид



4. ХАА-н техникийн дундын үйлчилгээний үндсэн загварууд болох ТЗДТ, ХАА-н туслан гүйцэтгэгчид, хамтрал болон бусад загваруудын харьцуулалт

Герман улсад ХАА-н техникийн дундын үйлчилгээний гол нэгжүүд нь ТЗДТ-үүд боловч хамтын ажиллагааны бусад загварууд ч тодорхой хэмжээнд нэвтэрсэн. Жишээлбэл зарим ХАА-н техник үйлдвэрлэгчид болон ХАА-н туслан гүйцэтгэгчид техник түрээслүүлэх үйлчилгээ эрхэлдэг бол тариаланчид өөрсдөө ч бас төрөл бүрээр хоршиж, хамтран ажиллаж байна. Туслан гүйцэтгэгчид олон тариаланчдад хүрч үйлчилдэг бол тариаланчдын хамтралууд харьцангуй жижиг буюу голчлон 2-3 тариаланч нэгдэж, ХАА-н техникээ, мөн зарим тохиолдолд тариалангийн талбай, барилга байгууламжаа хамтран ашигладаг. Мөн тариаланчид бүтээгдэхүүнийг нь худалдан авдаг ААН-тэй нэгдэх хувилбар ч бий.

Аж ахуйн нэгжийн түвшинд хамтран ажиллах аль ч хувилбарт ялгаагүй үйлчлэх чухал зарчим бол гишүүд нь хамтран ажиллах чадвартай байх шаардлагатай. Хамтын ажиллагаа нягтрах тусам гишүүд эдийн засгийн хувьд бие биенээсээ хамааралтай болж, хувийн эрх чөлөө, аж ахуйгаа дураараа эрхлэх боломж нь хумигдах тул эдийн засаг, хууль эрх зүйн болон хувь хүнд чиглэсэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ нэмэгдэнэ.

ДУНДЫН МЕХАНИКЖУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУД

Зохион байгуулалтын хэлбэр	Тариаланчдын тоо	Эрх зүйн зохицуулалт	Зөвлөх үйлчилгээний хэрэгцээ	Хувийн эрх чөлөө
Түрээсийн техник	50-с дээш			
Техник зуучлалын дундын төв	200-с дээш			
Туслан гүйцэтгэгч	20-50			
ХАА-н техникийн хамтрал, жижиг	2			
ХАА-н техникийн хамтрал, том	3-7			
Тариаланчдын хамтрал	2-10			
Тариаланчид, боловсруулах үйлдвэрийн хамтрал	2-50			
Аж ахуйнуудын бүрэн бус нэгдэл	2-3			
Аж ахуйнуудын нэгдэл	2			
Хоршоо	2-с дээш			
Аж ахуйн менежментийн иж бүрэн үйлчилгээ	5-с дээш			



Харилцан хүндэтгэлд тулгуурласан харьцаа маш чухал. Гишүүд нь нийтийн эрх ашгийг тэргүүнд тавьж, хувийн ашиг сонирхлоо хязгаарлаж чаддаг байх нөхцөлд л аливаа хамтрал амжилттай ажиллах боломжтой. Хэрэв ийм чадвар дутмаг бол тариаланчид хоорондоо нэгдэхийн оронд туслан гүйцэтгэгчид, ТЗДТ-үүдтэй хамтран ажиллах нь илүү үр дүнтэй. ТЗДТ тариаланчдыг мэдлэг, түршлагаа хуваалцаж, хамтран ажиллах боломжоор хангахаас гадна хамтын ажиллагааны төрөл бүрийн загваруудыг нэвтрүүлж болно. Ер нь ТЗДТ-үүд орон нутгийнхаа тариаланчдын бусад байгууллагуудтай нягт холбоотой, хамтран ажилладаг.

ТЗДТ БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БУСАД ХЭЛБЭРҮҮДИЙН ХООРОНДОХ ХАМТЫН АЖИЛЛАГАА



ХАА-н туслан гүйцэтгэгчид, хамтралууд, ТЗДТ-үүдийн үйлчилгээний цар хүрээг доорх хүснэгтэд харьцуулан үзүүлэв.

ХАА-н техникийн дундын үйлчилгээний байгууллагуудаас тариаланчдад үйлчилгээ үзүүлэх чиглэлүүд

	Туслан гүйцэтгэгч	Нөхөрлөл	ТЗДТ
Хөрс боловсруулалт	x	x	x
Үрлэгээ	x	x	x
Ургалтын үеийн арчилгаа	x	x	x
Ургац хураалт	x	x	x
Ложистик	x	x	x
Худалдан авалт/Борлуулалт		x	x
Туслах ажилчид ажиллуулах			x
Хөдөлмөр зохион байгуулалт			x
Нэмэлт орлого олох			x
Зөвлөх үйлчилгээ			x
Хөдөлмөрийн аюулгүй байдал			x
Баримтжуулалт	x		x
Сэргээгдэх эрчим хүч			x
Даатгал			x
Барилга, байгууламж барих		x	



5. ХАА-н техникийн дундын үйлчилгээний давуу талууд ба эрсдэлүүд

Тариаланчдын байр сууринаас авч үзвэл ХАА-н техникийн дундын үйлчилгээг хэрхэн зохион байгуулахаас үл хамааран тодорхой давуу ба сул талууд үргэлж дагалддаг. Тариаланч бүр дараах давуу тал, эрсдэлүүдийг харьцуулж үзсэний үндсэн дээр аж ахуйнхаа нөхцөл байдалд тохирсон шийдвэр гаргах учиртай.

Ямар давуу талуудтай вэ?

Механикжуулалтын зардал буурна
 Санхүүгийн хомсдолд орох аюул багасна
 Сүүлийн үеийн ХАА-н техник ашиглах боломжтой
 Мэргэшсэн ажилтнууд ажиллуулах боломжтой
 Ажлын ачаалал жигд хуваарилагдана
 Ажиллах хүч хэмнэнэ
 Ажлыг зохистой цаг хугацаанд нь багтаан гүйцэтгэнэ
 Хэрэв өөрөө техникээ бусдад түрээслүүлбэл нэмэлт орлого олно

Ямар эрсдэлүүд тохиолдож болох вэ?

Ажлыг цаг хугацаанд нь багтаахгүй байх, түүнээс шалтгаалж нэмэлт зардал гарах.
 Хэрэв захиалсан ажлыг туслан гүйцэтгэгч, хамтрал, эсвэл ТЗДТ цаг хугацаанд нь багтаан гүйцэтгэхгүй бол нэмэлт зардал гарах эрсдэл үүснэ. Жишээлбэл үр тарианы ургац хураалтыг оройтуулбал будаа хатаах зардал ихэснэ. Ногоон тэжээлийн хураалтыг оройтуулбал саалийн үнээний саам багасна. Түүнчлэн үрлэгээг оройтуулснаас шалтгаалж таримлын ургац буурах эрсдэл үүсэж болно. Иймд дундын техникийн үйлчилгээг төлөвлөхдөө тухайн орон нутгийн хөрс, цаг агаарын нөхцлийг сайтар судалж, тариаланчдад нэмэлт зардал үүсгэхээс аль болох сэргийлэх ёстой.

6. Монгол оронд ХАА-н техникийн дундын үйлчилгээг нэвтрүүлэх зөвлөмж

Доорх зөвлөмжийг боловсруулахдаа Монголын газар тариалан эрхлэгчдийг талбайн хэмжээнээс нь хамааруулан гурван бүлэгт баримжаалан ангилж, бүлэг тус бүрийн онцлогт нийцүүлэхийг зорьсон болно.

1-р бүлэг: 500-с дээш га талбайтай тариаланчид. Энэ бүлэгт багтах газар тариалан эрхлэгчид шаардлагатай ХАА-н техникээ өөрсдөө худалдан авах чадавхтайгаас гадна бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжтой тул үйлдвэрлэлийн нэгжид ногдох механикжуулалтын зардал харьцангуй бага гардаг давуу талтай. Хэрэв ХАА-н техниктэйгээс гадна уг техникийг зөв зохистой ашиглах чадвартай ажилтнууд аж ахуйд нь хүрэлцээтэй бол механикжуулалтад туслан гүйцэтгэгч хөлсөлснөөс өөрөө гүйцэтгэсэн нь өртөг багатай. Учир нь туслан гүйцэтгэгчдийн төлбөрт ажил гүйцэтгэлийн хөлснөөс гадна өөрсдийнх нь хүртэх ашиг шингэсэн байдаг. Механикжуулалтын тодорхой хэсгийг туслан гүйцэтгэгчдэд буюу ТЗДТ-д хариуцуулах нь ашигтай юу гэдэг шийдвэр үндсэндээ тухайн аж ахуйд ХАА-н техникээр мэргэшсэн ажилчид хүрэлцээтэй эсэх, мөн тэдгээрийн цалин урамшууллын хэмжээнээс хамаарна.

2-р бүлэг. 100-500 га талбайтай тариаланчид. Энэ бүлгийн ихэнх тариаланчид мөн л өөрсдөө аж ахуйгаа механикжуулах чадвартай боловч үзэж байна. Техникийн бүрэн хүчин чадлаар ашиглах боломж харьцангуй сайтай тул нэгж талбайд ногдох механикжуулалтын зардал бага буюу өөрөөр хэлбэл өөрийн механикжуулалт нь туслан гүйцэтгэгч хөлслөх, эсвэл түрээсийн техник ашигласнаас хямд тусна. 1-р бүлгийн тариаланчдын адилаар энэ бүлгийн тариаланчдын хувьд ч гэсэн техник худалдан авах уу, эсвэл түрээслэж ашиглах уу гэдэг шийдвэрийг гаргахад гол нь мэргэшсэн ажилтнуудын хүрэлцээ, мөн магадгүй хөрөнгийн чадавх гол шалгуур үзүүлэлтүүд болно.



3-р бүлэг: 10-100 га талбайтай төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчид. Энэ бүлгийн тариаланчдад ХАА-н техникийн дундын үйлчилгээ хамгийн их хэрэгцээтэй. Дундын үйлчилгээг зохион байгуулах үндсэн шийдэл нь Техник Зуучлалын Дундын Төв юм. Нэг ТЗДТ 200-гаас цөөнгүй тариаланчдад үйлчилж байж зардлаа нөхөж тогтвортой ажиллах боломжтой. Ийм төвлөрөл үүсгэж чадах эсэхийг газар дээр нь судлах нь зүйтэй. Техникийн хангамжийг шийдвэрлэх нэг гарц нь 1 ба 2-р бүлгийн тариаланчдыг техник түрээслүүлэгч гишүүнээр татан оролцуулах хувилбар байж болно. Хэрэв энэ хувилбар бүтэх боломжгүй бол ногоочдын хамтрал (орч. хоршоо, нөхөрлөл г.м.) байгуулах хувилбарыг сонгоно. Энэ тохиолдолд мөн л гишүүн ногоочдын механикжуулалтын хэрэгцээг агротехнологийн үйлдэл тус бүрээр зөв тооцох, талбайд хийгдэх ажлыг тухайн нутгийн хөрс, цаг уур, зах зээлийн онцлогоос хамааран ямар цаг хугацаанд зохион байгуулах талаар сайтар судлах шаардлагатай. Судалгааны үр дүнд суурилан ТЗДТ-д шаардагдах хөрөнгө оруулалт, ажиллах хүчний хэрэгцээг тооцож, дундын техникийн ашиглалтын зардлыг үйлдвэрлэлийн нэгж тутамд тооцон гаргах боломжтой.

Шаардлагатай дундын техникийг хамтралын гишүүд өөрсдөө хамтран худалдан авч, эзэмших, харин ашиглалт, засвар үйлчилгээг нь ТЗДТ хариуцах зарчмаар ажиллах тохиолдолд банкны зүгээс санхүүжүүлэх хандлага нь арай илүү байх магадлалтай.

Зөвлөмжийг ажил болгохын тулд дээр дурдсанчлан тариаланчдын механикжуулалтын эрэлт, хэрэгцээний судалгааг бүлэг тус бүрээр газар дээр нь гүйцэтгэх, ялангуяа ногоочдын хувьд механикжуулалтын хамтрал байгуулж, ажиллуулах эдийн засгийн тооцоог загварчлан гаргаж, холбогдох талуудаар хэлэлцүүлэх шаардлагатай. Үүнд мэргэжлийн хүмүүс, зөвлөхүүд оролцоо чухал үүрэгтэй. Зайлшгүй анхаарах асуудал бол хэн нэгний гаргасан шийдвэрийг тариаланчдад тулгах бус, харин мэргэжилтнүүдийн тусламжтайгаар тариаланчид гарц шийдлээ өөрсдөө тодорхойлж, хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлэх нь чухал.

Товч намтар:

1982 – 1984 онд ХАА-н МСҮТ-д суралцсан;
 1986 – 1989 онд ХАА-н их сургуульд суралцсан;
 1990 – 2003 онд Харбург дүүргийн ТЗДТ-ийн гүйцэтгэх захирлын туслах;
 1999 онд газар тариалан, ойн аж ахуй, үл хөдлөх хөрөнгө түрээслүүлэх үйлчилгээ эрхэлдэг өрхийн аж ахуйг эцэг эхээс өвлөж авсан;
 2003 оноос Харбург дүүргийн ТЗДТ, түүний охин компаниудын гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
 2012 оноос “Германы ТЗДТ-үүд” ХХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүн, “Германы ТЗДТ-үүдийн холбоо”-ны Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн;
 2016 оноос “Германы ТЗДТ-үүдийн холбоо”-ны гадаад харилцааны төлөөлөгч;
 2021 онд Кени улсад ТЗДТ-үүд байгуулах чиглэлээр богино хугацааны зөвлөхөөр ажилласан;
 2022 ба 2023 онд Герман-Тайландын хамтын ажиллагааны төслийн хүрээнд Тайланд улсын кластер аж ахуйнуудыг механикжуулах чиглэлээр богино хугацааны зөвлөхөөр ажилласан;
 2023 оноос Руанда улсад ТЗДТ-үүд байгуулах чиглэлээр зөвлөхөөр ажиллаж байна.

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогч

Андреас Хастедт
 Харбургийн Техник Зуучлалын Дундын Төвийн гүйцэтгэх захирал, тариаланч
 Имэйл: hastedt@mr-harburg.de